

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ЯВЦАД 2018 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2018 оны 06 дүгээр сарын 22

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн жилд тавьсан зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2018 оны хагас жилийн тайлан, бодлогын газруудын үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтэд үндэслэн гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлэх хугацаанд хийсэн ажлын гүйцэтгэлийг тухайн /2018/ оны хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 36 зорилтын 105 арга хэмжээ, үүнээс 76 арга хэмжээг толгойлон, 28 арга хэмжээг хамтран, 1 арга хэмжээг оролцогчоор хэрэгжүүлэхээр тусгагдсаныг хяналтанд авч сайдын 2017 оны А/22 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2017 оны жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /unelgee.gov.mn/ цахим системд байршуулсан 28 зорилтын 85 арга хэмжээг хяналтанд авч үнэлгээ хийж хүргүүлсэн бол 2018 оны хагас жилийн үнэлгээг 25 зорилтын 64 арга хэмжээний хүрээнд хийлээ. Энэ нь 2016-2017 онд хэрэгжүүлэх 15, 2017 онд хэрэгжүүлэх 13, нийт 28 арга хэмжээ хяналтаас хасагдаж 7 арга хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

Хяналтанд авагдсан 64 арга хэмжээний 48 арга хэмжээг яам толгойлон, 16 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлогын хүрээний 1 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 55.0 хувь,

- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын хүрээний 20 зорилтын 54 арга хэмжээний биелэлт 64,5 хувь,
- Нийгмийн бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөөгүй,
- Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын 3 зорилтын 7 арга хэмжээний биелэлт 40,0 хувь, хэрэгжүүлсэн нийт 64 арга хэмжээний биелэлтийг 61,7 хувьтай дүгнэлээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО
/2018 оны хагас жил/

Зорилт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо					Хэрэгжилт /хувь/
			100	70	40	0	/-/	
Нэг. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого	1	2		1	1			55,0
Хоёр. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	20	54	10	16	18		10	64,5
Гурав. Нийгмийн бодлого	1	1					1	/-/
Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	3	7			5		2	40,0
Дүн	25	64	10	17	24		13	61,76

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг хэрэгжүүлэх он тус бүрээр үзүүлэв.

Хэрэгжүүлэх он	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн дундаж, %	
		2018 хагас жил	2018 жилийн эцэс
2017	13	64,0	-
2016-2017	15	76,9	-
2016-2018	2	70,0	-
2016-2019	5	46,0	-
2016-2020	28	65,0	-
2017-2018	7	75,0	-
2017-2020	14	48,1	-

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 10 арга хэмжээний биелэлтэд **100 хувийн үнэлгээг өгөв.**

- ✓ 2.17.1. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг шинэчлэн найруулах
- ✓ 2.17.3. Алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүстэй ойролцоо түвшинд барих бодлогыг баримтлах
- ✓ 2.17.4. Улсын болон компанийн нөөцийг бүрдүүлэх
- ✓ 2.48.6. “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийг боловсруулан батлуулах
- ✓ 2.59.1. Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулах
- ✓ 2.60.2. Үндэсний геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах, мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг боловсруулах, түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгох

- ✓ 2.61.4. Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- ✓ 2.62.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулах талаар судалгаа хийж, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийг ил тод, нээлттэй түгээх аргачлалын санал боловсруулах
- ✓ 2.63.2. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах
- ✓ 2.69.3. Алтны геологийн судалгаа, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын хэмжээг өсгөн нөөцийг тогтвортой нэмэгдүүлэх

70 хувийн биелэлттэй:

- 1.24.2. Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх
- 2.11.3. Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, улмаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх
- 2.17.5. Аймаг, нийслэл, сумдын хэрэглээнд үндэслэн шатахуун түгээх станц, агуулахын оновчтой сүлжээг бий болгох
- 2.17.6. Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөн болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулах
- 2.17.7. Гашуун сухайт, Ханх, Хавирга зэрэг боомтуудаар бүтээгдэхүүн тогтмол импортлох ажлыг эхлүүлэх, улмаар тээвэр ложистикийн зардлыг бууруулах, өртгийг багасгах судалгаа хийх
- 2.59.9. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордод стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, хамтарсан компани байгуулах
- 2.60.1. Үндэсний геологийн алба байгуулахдаа хууль, эрх зүй, эдийн засгийн үр өгөөж, гадаад улсуудын ижил төстэй байгууллагуудын талаар иж бүрэн судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулж, ЗГ, УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах, үйл ажиллагааг эхлүүлэх
- 2.60.5. Гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлын төслийг хэрэгжүүлэх, үр дүнгийн тайланг хүлээн авах
- 2.63.3. Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын болон эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх
- 2.63.5. Газрын тосны ордын дэд бүтэц, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх
- 2.63.7. Газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлцлүүдийг хийж, үнэ болон худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлэх
- 2.63.8. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явагдаж буй газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлж, шинээр газрын тосны орд илрүүлэх
- 2.63.9. Газрын тос болон уламжлалт бус газрын тосны хуримтлал байж болох газарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх
- 2.63.10. Хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр газрын тосны олборлолтоос гарч байгаа газрын тосны ууссан хийг ашиглах чиглэлээр судалгаа хийх, ашиглах
- 2.63.11. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй талбайд ой хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зурвас бүсийг байгуулах
- 2.64.2. Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг зохион байгуулах
- 2.69.2. Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах

40 хувийн биелэлттэй:

- 1.24.3. Цагаан суварга төслийг хэрэгжүүлэх
- 2.59.2. Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг нэгтгэх
- 2.59.3. Монгол Улсын баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг хэрэгжүүлэх
- 2.59.4. Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан геохимийн судалгаа хийх
- 2.59.5. Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэх газар болон томоохон хот суурин газрын геоэкологийн болон гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх
- 2.59.6. Эрдэс баялгийн хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газар, улсын хил орчмын нутаг дэвсгэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулан сэдэвчилсэн судалгааны төсөл хэрэгжүүлэх
- 2.59.8. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг төлөвлөх
- 2.61.1. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ГБГ
- 2.61.2. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах
- 2.61.6. Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гадаад орнуудаас ирүүлсэн саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- 2.63.4. Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх
- 2.63.6. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлж, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх
- 2.63.12. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах
- 2.67.2. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх
- 2.69.6. Ашиглалтад оруулахад бэлэн болсон алтны уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх
- 2.69.7. Бичил уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судалж хэрэгжүүлэх
- 2.70.4. Барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах
- 2.74.1. Улаанбаатар хотод жилд 15,000 тн тос, тосолгооны материал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжих
- 2.75.1. Автомашин, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэр, технологийн парк байгуулахыг дэмжих
- 4.2.6.1. Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хохирлыг тооцох, нөхөн сэргээх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, нөхөн сэргээлт хийх
- 4.2.6.3. Аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, чадавхийг бэхжүүлэх замаар нөхөн сэргээлтийн ажлын чанар үр дүнг дээшлүүлэх, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- 4.2.6.4. Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр хэрэгжүүлж, холбогдох стандартуудыг шинэчлэх, сургалт, судалгааны төв байгуулах
- 4.2.6.5. Орхон, Туул гол болон бусад голуудын хамгаалалтын бүсэд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийг хууль

тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах, хариуцлагатай уул уурхайн зарчмыг мөрдүүлж усны бохирдлыг бууруулах

➤ 4.2.6.6. Баруун бүсэд дүйцүүлэн хамгааллын жишиг төсөл хэрэгжүүлэх

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас хамтран ажиллах санал ирүүлээгүй, яамны зүгээс тодорхой хийгдсэн ажлын биелэлтгүй 13 арга хэмжээний биелэлтэд **үнэлгээ өгөөгүй**. Үүнд:

Яам толгойлон хэрэгжүүлэх 5 арга хэмжээ:

- 2.65.2. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангах /УУБГ/
- 2.71.3. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулах /ХҮБГ/
- 2.72.3. Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэр байгуулах /ХҮБГ/
- 2.72.4. Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах /ХҮБГ/
- 2.73.5. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, барилгын зураг төсөл боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах /ХҮБГ/

Бусад байгууллага толгойлон хэрэгжүүлэх 8 арга хэмжээ:

- 2.48.7. "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах /ХХААХҮЯ/
- 2.59.10. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул, геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх /АМГТГ, ЦЭКАА/
- 2.72.6. Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, импортын хэмжээг бууруулах /БХБЯ/
- 2.92.2. Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх /БХБЯ/
- 2.99.3. Хашаат цав, Тэвшийн говийн орд газруудыг түшиглэн том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, нүүрсний уурхай байгуулах төслүүдийг эхлүүлэх /ЭХЯ/
- 3.2.33.10. Уул уурхай, шинжлэх ухааны чиглэлд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэх /ЦЭКАА/
- 4.1.3.1. Байгаль орчны үнэлгээ, аудитаар дамжуулан ашиглагч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх /БОАЖЯ/
- 4.2.3.2. Ус ашиглалтыг бүрэн тоолууржуулж, хаягдал бохир усыг цэвэрлэж, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах /БОАЖЯ/

Дөрөв. Дүгнэлт.

- Ажил хариуцсан нэгж, мэргэжилтнүүд төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухайн онд хүрэх түвшинтэй нийцүүлж биелэлтийг тайлагнахгүй байна.

Яамны зүгээс бодитой ажил хийгдээгүй. /1.24.2.-УУБГ/.

<p>Далд уурхайн ажлын гүйцэтгэл 45 хувь</p>	<p>Оюу толгойн зэс алтны ордыг ашиглах далд уурхайн бүтээн байгуулалтад 2018 онд 1,076.3 сая ам.доллар оруулахаар төлөвлөснөөс эхний улирлын байдлаар 477.4 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг оруулсан байна. 2018 онд далд уурхайн хэвтээ малталтын нэвтрэлтэд 11159 метр нэвтрэхээр төлөвлөснөөс 5 дугаар сарын байдлаар 4110 метр, мөн конвейрын налуу аманд 4320 метр нэвтрэлт хийхээр төлөвлөснөөс 1301.4 метр тус тус нэвтэрч, 5 дугаар босоо амны нэвтрэлт 92.5 метрээр гүнзгийрсэн байна. Далд уурхайн нэвтрэлт бүтээн байгуулалтын ажил хийхээс гадна ил уурхай, баяжуулах үйлдвэр ажиллаж байна. 2018 онд ил уурхайгаас 43328 мян.тонн хүдэр олборлохоор төлөвлөснөөс эхний 5 сарын байдлаар 16716 мян.тонн хүдэр олборлосон байна. Баяжуулах үйлдвэр 2018 онд 582.6 мян.тонн зэсийн баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөснөөс эхний 5 сарын байдлаар 21.9 хувийн дундаж агуулагатай 296.6 мян.тонн баяжсал үйлдвэрлэн 303.3 мян. тонн баяжмал экспортлосон байна. Оюутолгой ХХК нь 1 дүгээр улирлын байдлаар улсын төсөвт 94377.5 сая төгрөг, орон нутгийн төсөвт 26567.2 сая төгрөгийн тус тус оруулж орон нутгийн хөгжлийн санд 5 сая ам.доллар зарцуулахаас одоогийн байдлаар 2.7 сая ам.долларыг оруулаад байна. Далд уурхайн ажлын гүйцэтгэл 5 сарын 1-ний байдлаар 31,3%-тай байна.</p>
---	--

Утга агуулга нь зорилттойгоо уялдаагүй, төлөвлөсөн болон зарцуулсан хөрөнгө оруулалтын талаар мэдээлэлгүй /2.63.9.-ТБГ/

<p>Эрэл, хайгуул, үнэлгээний ажлыг эрчимжүүлж, тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэх. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 5,000.0</p>	<p>Газрын тосны 25 талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаагаас 2016 онд Эргэл XII, Арбулаг ХХИХ талбайд БХГ-г гэрээг шинээр байгуулсан. Мөн нүүрсний давхаргын метан хийн 5, шатдаг занарын 3, газрын тосны 10, нийт 18 талбайд эрлийн гэрээ байгуулан, хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Жи Эү Эйч ХХК нь Газрын тосны тухай хуулийн 16-р зүйлийн дагуу 2016 оны 1-р сарын 15 -нд “Номгон-IX” газрын тосны хайгуулын талбайд НДМ хийн эрлийн ажил хийж гүйцэтгэх гэрээг Газрын тосны газартай (ГТГ, хуучнаар) байгуулсан. Эрлийн ажлын хүрээнд өмнөх хайгуул судалгааны материалыг нэгтгэх, тойм нөөцийн үнэлгээ, хайгуулын ажлын хөтөлбөр боловсруулах ажлуудыг гүйцэтгэж, Газрын тосны тухай хуулийн 17.1-р заалтын дагуу 2016 оны 7-р сарын 21-ний өдөр ГТГ-аар дүгнэлт гаргуулсан байна. Газрын тосны тухай хуулийн 17.2-р заалтын дагуу “Номгон-IX” талбайд байгуулах нүүрсний давхаргын метан хийн Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний төслийг Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-т өргөн барьж, 17.4-р заалтын дагуу АМГТГ-тай БХГ-ний хэлэлцээрийг хийж гүйцэтгэн 2017 оны 5-р сарын 3-ны өдөр хэлэлцэн тохирсон БХГ-ний төслийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)-нд ирүүлсэн. Гэрээний төсөлд 2017 оны 8 дугаар сард, 2018 оны 2 дугаар сард яамдуудаас санал авч ЗГХЭГ-т Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн боловч холбогдох материалыг буцаагаад байна. “Говийн гарц” ХХК нь Газрын тосны газар /хуучин нэрээр/-тай 2014 онд эрлийн гэрээ байгуулж, эрлийн ажлын тайлангаа 2017 оны 2 сард АМГТГ хүлээлгэн өгсөн бөгөөд 2017 оны 11-р сарын 01-ний өдөр АМГТГ-ийн “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын техникийн зөвлөл”-өөр уг тайланг хэлэлцэн хүлээн авсан. “Говийн гарц” ХХК нь газрын тосны тухай хуулийн дагуу эрлийн гэрээний хүрээнд хийгдсэн ажлын үр дүнд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулахаар Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/ байгуулах хүсэлтээ 2018.01.3-ны өдөр Ашигт малтмал, газрын тосны газар /АМГТГ/-т ирүүлсэн байна. Уг гэрээний төслийн 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр УУХҮЯ-нд ирүүлсэн. Гэрээний төслийг судлан үзээд бүх яамдуудаас гэрээний төсөл болон Засгийн газрын тогтоолын төсөлд санал авч нэгтгэж байна.</p>
--	---

2017 оны жилийн эцсийн биелэлтийг дахин ирүүлсэн: /2.56.10.-БХЗГ/

Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн талбайнуудад судалгаа, эрэл, хайгуулын ажлыг эхлүүлэх	Цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийн мэдээг хагас жил тутам Цөмийн Энергийн комиссын ажлын албанд хүргүүлж байна. Тайлбар: Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн чиглэлээр хайгуул хийж буй компаниуд жил бүр хөрөнгө оруулалтын боломжоороо ажлаа гүйцэтгэж буй бөгөөд төрийн байгууллагын үйл ажиллагаанаас хамааралгүйгээр хийгдэж байна. Одоогоор аж ахуйн нэгжтэй мэдээлэл солилцох хэмжээнд ажил явагдаж байна. Судалгаа, хөрөнгө оруулалт татах чиглэлээр Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн болон хайгуулын ажлын мэдээлэл, тогтоогдсон нөөц, өнөөгийн үнэ ханш, зах зээлийн судалгаа, хэтийн төлөвийн талаарх мэдээлэл бэлтгэсэн. Мөн 2017 онд дууссан “Монгол орны газрын ховор элементийн металлогени, түүний төлөвийн судалгаа”-ны төслийн явц болон үр дүнгийн талаар танилцуулга хийгдсэн.
--	--

Биелэлтийг тодорхойгүй, тайлбар үндэслэлгүй ирүүлсэн: /2.61.2.-УУБГ/

Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар батлуулах	Уул уурхайн тухай хуулийн төсөлд Ил тод байдлын асуудлаар бие даасан бүлэг оруулж боловсруулсан.
---	--

/2.65.2.-БХЗГ/

Дэд бүтцийн хөгжлийн төсөл хэрэгжүүлэх	Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрийн төслийг боловсруулсан ба салбар хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор Үндэсний хөгжлийн газарт төслийг хүргүүлээд байна.
--	---

Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл үр дүнгүй: /2.72.3.-ХҮБГ/

Үйлдвэр ашиглалтад орох	Төмөртэйн уурхайд байгуулах хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн барилгын ажлыг 2018 оны 8 дугаар сард эхлүүлж 2020 оны 9 дүгээр сард дуусган мөн оны 12 сард үйлдвэрийг бүрэн ашиглалтанд хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлууд хийгдэж байна.
-------------------------	---

- Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад бэрхшээлтэй, тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас ханддаггүй байдал давтагдаж байна. Төлөвлөгөөний 4.2.6-д тусгагдсан /үндсэн хэрэгжүүлэгч БОНХЯ/ 5 арга хэмжээний биелэлт шинэчлэгдээгүй, 2017 оны жилийн эцсийн биелэлтийг дахин ирүүлсэн /БХЗГ/.
- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 2018 оны хагас жилийн байдлаар 61,7 хувьтай дүгнэснээс 10 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 17 арга хэмжээ 70 хувь, 24 арга хэмжээ 40 хувийн тус тус хэрэгжилттэй, тасарсан арга хэмжээ байхгүй.

Тав. Санал, зөвлөмж.

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын цахим сайтад яамны хамтран хэрэгжүүлэгчээр тусгагдсан зорилт, арга хэмжээг хяналтаас хасах,
2. Хэрэгжүүлэх хугацаа өнгөрсөн хэдий ч гүйцэтгэл нь бүрэн хэрэгжээгүй арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжиж дуустал цахим сайтад хяналтанд байлгах,
3. Хэрэгжилт удаашралтай /40-өөс 70%-тай/ арга хэмжээний хэрэгжилтийг сүүлийн хагас жилд бүрэн хангах, зорилтот түвшинд хүргэх, ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах, ажлын уялдааг сайжруулах,

4. Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжилтийг хангах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагад асуудал тавьж ажиллах,
5. Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг тухайн онд хүрэх түвшинтэй нь нийцүүлж утга агуулга, өгүүлбэр найруулга, үг үсгийн алдаагүй, товч бөгөөд тодорхой ирүүлж байх,
6. Зарцуулсан хөрөнгө оруулалтын хэмжээг төлөвлөгдсөн дүнтэй нь харьцуулан гаргаж байх,
7. Биелэлтийг УУХҮСайдын 2017 оны А/22 дугаар тушаалын хавсралтад заасан хугацаанаас хоцроогүй ирүүлж байх,
8. Биелэлтийг текст хэлбэрээс гадна хүснэгт, график, гэрэл зураг зэрэг бусад хэлбэрээр ирүүлж байхад бодлогын газруудын удирдлага, мэргэжилтнүүд анхаарч ажиллах шаардлагатай.

ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд 2018 оны хагас жилийн байдлаар хийсэн үнэлгээний тайланг хавсаргав.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан
“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны
байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3 дугаар хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ**

2018/06/21

/2018 оны хагас жил/

ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр, сая төгрөг)	Хэрэгжилтийн хувь	
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	%
1	2	3	4	5	6	7	8	9
НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ОНЦГОЙ БОДЛОГО								
1.24. “Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	2	Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх	2016-2020	УУХҮЯ УУБГ		2,600,000.0	Оюу толгойн зэс алтны ордыг ашиглах далд уурхайн бүтээн байгуулалтад 2018 онд 1,076.3 сая ам.доллар оруулахаар төлөвлөснөөс эхний улирлын байдлаар 477.4 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг оруулсан байна. 2018 онд далд уурхайн хэвтээ малталтын нэвтрэлтэд 11159 метр нэвтрэхээр төлөвлөснөөс 5 дугаар сарын байдлаар 4110 метр, мөн конвейрын налуу аманд 4320 метр нэвтрэлт хийхээр төлөвлөснөөс 1301.4 метр тус тус нэвтэрч, 5 дугаар босоо амны нэвтрэлт 92.5 метрээр гүнзгийрсэн байна. Далд уурхайн нэвтрэлт бүтээн байгуулалтын ажил хийхээс гадна ил уурхай, баяжуулах үйлдвэр ажиллаж байна. 2018 онд ил уурхайгаас 43328 мян.тонн хүдэр олборлохоор төлөвлөснөөс эхний 5 сарын байдлаар 16716 мян.тонн хүдэр олборлосон байна. Баяжуулах үйлдвэр 2018 онд 582.6 мян.тонн зэсийн баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөснөөс эхний 5 сарын байдлаар 21.9 хувийн дундаж агуулагатай 296.6 мян.тонн баяжсал үйлдвэрлэн 303.3 мян. тонн баяжмал экспортлосон байна. Оюутолгой ХХК нь 1 дүгээр улирлын байдлаар улсын төсөвт 94377.5 сая төгрөг, орон нутгийн төсөвт 26567.2 сая төгрөгийн тус тус оруулж орон нутгийн хөгжлийн	70
						Далд уурхайн ажлын гүйцэтгэл 45 хувь		

						санд 5 сая ам.доллар зарцуулахаас одоогийн байдлаар 2.7 сая ам.долларыг оруулаад байна. Далд уурхайн ажлын гүйцэтгэл 5 сарын 1-ний байдлаар 31,3%-тай байна.	
	3	Цагаан суварга төслийг хэрэгжүүлэх	2016-2020	УУХҮЯ УУБГ	Уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах	УУХҮЯ-ны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл /ЭБМЗ/-ийн хурлаар Цагаан суварга ордын зэсийн исэлдсэн хүдрийн нөөцийн тодотгол, жилд 5000 тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж хүлээн аваад байна. ЗГ-ын 2016 оны 208 дугаар тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөр”-т Цагаан суварга төслийг ашиглалтад оруулахаар тусгасан. Мөн Үндэсний хөгжлийн газраас боловсруулсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т Цагаан суваргын орд газрыг хамруулж холбогдох санхүүжилтийг Улсын хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэхээр тусган оруулсан.	40
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО							
2.11. Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.	3	Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, улмаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх	2017-2020	БХБЯ	Чөлөөт бүсийн хот төлөвлөлтийн баримт бичигтэй болох, дэд бүтцийн 2 дугаар ээлжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх	2017 оны 05 сарын 12-15-ны өдрүүдэд БНХАУ-д зохион баягуулагдсан "Бүс ба Зам" уулзалтанд МУ-ын ерөнхий сайд оролцохтой холбогдуулан айлчлалын удирдамж, хэлэлцээрийн сэдэвт тусгуулах саналыг ГХЯ-нд хүргүүлсэн. Мөн Талын зам болон "Бүс ба Зам" санаачлагыг уялдуулах тухай Засгийн газар хоорондын санамж бичгийн төсөлд ГХЯ-д 2017.05.02-ны өдрийн 01/1307 тоот, 2017.05.25-ны өдрийн 02/1577 тоотой тус тус санал өгсөн.	70
					-		

2.17. Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна.	1	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг шинэчлэн найруулах	2017-2018	УУХҮЯ ТБГ	Холбогдох байгуул лагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, хуульд өөрчлөлт оруулах	Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хүрээнд ХЗДХС/УУХҮС-ын 2017.12.13-ны өдрийн хамтарсан А/298/А/240 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсгийг байгуулан ажиллаж “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль”-ийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж, “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийн төслийг боловсруулж ЗГ-ын 2018 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Дээрх ажлын хэсгийн хүрээнд уг хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах замаар шинэчлэн найруулахгүйгээр нэмэлт өөрчлөлтүүдийг хийв.	100
	3	Алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүстэй ойролцоо түвшинд барих бодлогыг баримтлах	2016-2020	УУХҮЯ ТБГ	Газрын тосны бүтээгдэхүүний хил үнэ, валютын ханшийн өөрчлөлт болон бусад холбогдох зардалтай уялдуулан шатахууны жижиглэн борлуулж буй үнийн зохицуулал туг хийх	Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж, ажиллав. Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 26 дугаар тогтоолоор А-80 болон Аи-92 автобензиний онцгой албан татварын хэмжээг 0,0 төгрөгөөр тогтоож жижиглэн борлуулалтын үнийн огцом өсөлтийг саармагжуулсан. Мөн ЗГ-ын холбогдох шийдвэрийг гаргуулж импортлогч компаниудын татан авалтыг нэмэгдүүлж, нөөц бүрдүүлэх замаар шатахууны жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой хадгалсан. Алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүстэй ойролцоо түвшинд барихын тулд тухай бүр шуурхай арга хэмжээг тухай бүр авч, онцгой албан татварын хэмжээг бүс нутгаар нь ялгавартай тогтоосноор алслагдсан бүс нутаг болон төвийн бүсийн шатахууны үнийн зөрүү бага байна. Хүснэгтийг хавсаргав.	100
	4	Улсын болон компанийн нөөцийг бүрдүүлэх	2018	УУХҮЯ ТБГ	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 13.1-ийг хангах	Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 297 дугаар тогтоолоор 2018 онд бүрдүүлэх компанийн нөөцийн хэмжээг 94700 тонн байхаар тогтоосон. Тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч 21 аж ахуйн нэгжтэй компанийн нөөц бүрдүүлэх гэрээг байгуулж, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг агуулахын байршлуудаар нь нэгтгэн Төв, Баруун, Зүүн гэсэн 3 бүст хуваан хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна. 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 37 хоногийн нөөцтэй байгаа бөгөөд үүнээс А-80 автобензин 44, Аи-92 автобензин 35, дизелийн түлш 35, ТС-1 онгоцны түлш 39 хоногийн тус тус нөөц бүрдүүлсэн.	100

5	Аймаг, нийслэл, сумдын хэрэглээнд үндэслэн шатахуун түгээх станц, агуулахын оновчтой сүлжээг бий болгох	2018-2020	УУХҮЯ ТБГ		Холбогдох байгууллагуудт ай хамтарсан ажлын хэсэг байгуулж, судалгааны ажлыг эхлүүлэх	Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/61 тоот тушаалаар хүн амын нягтаршил ихтэй хот, суурин газар болон төв замын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, хийн байгууламжуудын улсын үзлэгийг эхлүүлээд байна. Үзлэгээр нийт 11 аймгийн 117 сумын нутаг дэвсгэр дэх агуулах, шатахуун түгээх станцыг хамруулахаар үзлэг эхлээд байна. Тус үзлэгийн үр дүнд газрын тосны бүтээгдэхүүний агуулах болон түгээх станцын, нэгдсэн бүртгэл шинэчлэгдэнэ. Өнөөдрийн байдлаар газрын тосны бүтээгдэхүүний /шатахуун/ импорт, бөөн болон жижиглэнгийн худалдааны 92 аж ахуйн нэгж, шингэрүүлсэн шатдаг хийн 37 аж ахуйн нэгж тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Дээрх аж ахуйн нэгжүүд нь Монгол Улсын хэмжээнд 98 газрын тосны бүтээгдэхүүний агуулах, 1267 шатахуун түгээх станц, 10 шингэрүүлсэн шатдаг хий хадгалах агуулах, 80 гаруй шингэрүүлсэн шатдаг хий түгээх станцуудаар дамжуулан газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, түгээлт, борлуулалтын үйл ажиллагаа явагдаж байна.	70
6	Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөн болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулах	2016-2020	УУХҮЯ ТБГ	100.0	Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн чанарын хяналтын тогтолцоог сайжруулах төлөвлөгөө боловсруулах	“Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт хийх, чанарын хяналтын журам боловсруулах зэрэг холбогдох заалтуудыг тусгав. Мөн “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2018 оны А/08 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Шинэчлэсэн журмаар газрын тосны бүтээгдэхүүний импортын тусгай зөвшөөрлийн хүрээг өргөтгөн керосин, нафта зэрэг нэмэлт бүтээгдэхүүнүүдийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр импортлох зохицуулалтыг хийсэн. Сайдын 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/224 тоот тушаалын дагуу УУХҮЯ, МХЕГ, НМХГ, АМГТГ-ын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилж, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний чанарт хяналт, шалгалт хийв. Мөн хүн амын нягтаршил ихтэй хот, суурин газар болон төв замын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, хийн байгууламжуудын улсын үзлэгийг эхлүүлээд байна. Үзлэгээр нийт 11 аймгийн 117 сумын нутаг дэвсгэр дэх агуулах, шатахуун түгээх станцуудын үзлэгт хамрагдах бөгөөд газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтыг хийж эхлээд байна. Яамны харъяа газрын тос, шатах ашигт малтмалын шинжилгээ, туршилтын лабораторит	70

						газрын тосны бүтээгдэхүүний сорилт гүйцэтгэх итгэмжлэл авснаар чанарын хяналтыг тавих боломж бүрдэж байна.		
	7	Гашуун сухайт, Ханх, Хавирга зэрэг боомтуудаар бүтээгдэхүүн тогтмол импортлох ажлыг эхлүүлэх, улмаар тээвэр ложистикийн зардлыг бууруулах, өртгийг багасгах судалгаа хийх	2016-2020	УУХҮЯ ТБГ	50.0	Судалгааны ажлын үр дүнг нэгтгэж, ажлын хэсгийн зөвлөмжийг үндэслэн холбогдох шийдвэрийг гаргах	70	
<p>Тэргүүлэх зорилт №2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөр, “ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100” хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН”-ыг шинээр эхлүүлж, “АТРЫН-III АЯН”-ыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.</p>								
2.48. Үйлдвэржилти	6	“Үйлдвэржилт 21:100”	2016-2020	ХХААХҮЯ ХҮБГ		-	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/157 дугаар тушаалаар байгуулагдсан “Үйлдвэржилт 21:100”	100

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

йн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.		хөтөлбөрийг боловсруулан батлуулах				Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	хөтөлбөр"-ийг боловсруулж батлуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллав. Ажлын хэсгээс Монгол Улсад хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийн танилцуулгыг боловсруулан Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын хуралдааны 2016 оны 60 дугаар тэмдэглэл гарсан. Уг тэмдэглэлд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах тухай санал гарсны дагуу ажлын хэсэг "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийг боловсруулж, яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлэн болгосон байна. Энэхүү ажлын хүрээнд Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл болон салбарын эрдэмтэн, доктор, ААН-үүдийн удирдлагуудтай 21:100 хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэх ажлыг УУХҮЯ-нд 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав. Хүнд үйлдвэрийн зөвлөлөөс 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 17/47 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг Ажлын хэсэгт хүргүүлэв. ХХААХҮЯ-ны 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/1470 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийн төсөлд санал боловсруулж, 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/1159 тоотой хариу хүргүүлэв.	
	7	"Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах	2016-2020	ХХААХҮЯ ХҮБГ		1,000,000.0 Үйлдвэрүүдийг барьж байгуулах бүтээн байгуулалтын ажил эхлэх, үндсэн дэд бүтэц нь шийдэгдсэн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эхлүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын 25-30 хувь нь хийгдэх	Хөтөлбөр батлагдсаны дараа дүрэм, журам гарна. Хугацаа болоогүй.	-/-
<p>Тэргүүлэх зорилт №2.3. Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.</p>								

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2.59. Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ.	1	Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулах	2016-2020	УУХҮЯ ГБГ	Батлагдсан – 4693.7 Гүйцэтгэл – 1061.2 Санхүүжилт – 753.2	8,100.0	Геологийн зураглалын Бурхант толгой-50, Цогт-50, Дэвсгийн нуруу-50, Улаан толгой-50, Хулгарын элс-50, Хөхөлзөгийн говь-50, Бударын чулуу-50, Шивээт уул-50 буюу нийтдээ 8 төслийн үр дүнг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж, УУХҮС-ын 2018 оны А/15, А/84, дугаар тушаалуудаар хүлээн авснаар нийт нутаг дэвсгэрийн 38.7%-ийг энэхүү масштабын зураглалд бүрэн хамруулсан. Төлөвлөгөөт онд үргэлжүүлэн хэрэгжүүлэх 18 төслийн хүрээнд нутаг дэвсгэрийн 4%-ийг хамруулахаар төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар батлан хэрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Эдгээрийн үр дүнд оны эцэст нийт нутаг дэвсгэрийн 42.7%-ийг судалгаанд хамруулж Монгол орны геологийн тогтоц, ашигт малтмалын хэтийн төлвийн үнэлгээг өгнө.	100
	2	Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг нэгтгэх	2017-2020	УУХҮЯ ГБГ	Батлагдсан - 408.5 Гүйцэтгэл - 158.8 Санхүүжилт - 112.3	600.0	Улсын геологийн иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд 2016-2020 онд нэгтгэх төслийн 2018 оны хэрийн болон суурин боловсруулалтын ажлын арга аргачлал, хэмжээ, төсвийг ЭБМЗ-ийн 3-р сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, 2018 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/03 дугаар тушаалаар батласан. Төслийн 2018 оны хэрийн судалгааны ажил эхэлсэн бөгөөд энэ онд К хавтгайн нутаг дэвсгэрийн 25%-ийг хамруулна. Монгол орны L хавтгайн хэмжээнд УГЗ-200 зураг нэгтгэх ажлыг 2018 онд эхлүүлэхээр саналыг бэлтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн боловч 2018 оны төсөв хязгаартай батлагдсанаас шалтгаалан тухайн төслийг дараа онд эхлүүлэхээр шилжүүлэх шаардлагатай болсон. Иймд МУ-ын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл болон 2019 оны төсвийн хүрээний саналд энэхүү төслийг тусгуулахаар холбогдох материалыг боловсруулж 2018 оны 3-р сарын 09-ний өдрийн 03/645 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.	40
	3	Монгол Улсын баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг хэрэгжүүлэх	2016-2020	УУХҮЯ ГБГ	/-/	1,300.0	Монгол орны баруун өмнөд хэсэгт, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь аймгуудын урд хэсгийн нийт 207,094.0 км ² талбайг хамруулан 2014-2017 онд гүйцэтгэсэн 1:200000-ны масштабын агаарын геофизикийн 5 сувгийн судалгааны Алтай-1, Алтай-2 төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2018 оны 4-р сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж хүлээн авсан. Үүний үр дүнд нийт нутаг дэвсгэрийн 13.2%-ийг агаарын геофизикийн судалгаанд нэмж хамруулсан. Ховд-1 төслийн гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй учир захиалагч /УУХҮЯ-ны ТНБД/-ийн 2018 оны 6-р сарын 15-ны өдрийн 03/1638 тоот шийдвэрээр гэрээг цуцалж, МУ-ын эдийн засаг, нийгмийг 2019 онд	40

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

							хөгжүүлэх Үндсэн чиглэл болон 2019 оны төсвийн хүрээний саналд уг төслийн судалгааг 2019 онд дахин шинээр тусгуулахаар холбогдох материалыг боловсруулж 2018 оны 3-р сарын 09-ний өдрийн 03/645 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.	
4	Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан геохимийн судалгаа хийх	2017-2020	УУХҮЯ ГБГ	/-	700.0 Геохимийн суурь судалгааны ажлыг томоохон хот, суурин газруудын хэмжээнд хийж эхлэх	Геохимийн судалгааны ажлыг эхлүүлэхээр саналыг бэлтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн боловч төлөвлөгөөт оны төсөв хязгаартай батлагдсан нь тухайн төслийг 2018 онд эхлүүлэх боломжгүй болгосон. Иймд МУ-ын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл болон 2019 оны төсвийн хүрээний саналд энэхүү төслийг тусгуулахаар холбогдох материалыг боловсруулж бэлтгэн 2018 оны 3-р сарын 09-ний өдрийн 03/645 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.	40	
5	Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэх газар болон томоохон хот суурин газрын геоэкологийн болон гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх	2017-2020	УУХҮЯ, БОАЖЯ ГБГ	Батлагдсан – 766,1 Гүйцэтгэл – 251.7 Санхүүжилт – 251.7	400.0 Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэж байгаа нутаг дэвсгэрт геоэкологи, гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажлыг эхлүүлэх	Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологи-2017 төслийн ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар батласан. Төслийн 2018 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын төсөл, төсөвт хийх тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцэж, УУХҮС-ын тушаалаар батлан энэ 2018 оны судалгааны ажлыг эхлүүлсэн.	40	
6			УУХҮЯ		3,200.0			40

		Эрдэс баялгийн хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газар, улсын хил орчмын нутаг дэвсгэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулан сэдэвчилсэн судалгааны төсөл хэрэгжүүлэх	2017-2020	ГБГ	Батлагдсан-6456.3 Гүйцэтгэл - 1180.0 Санхүүжилт – 644.2	Металл бус болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хэтийн төлвийн судалгааны ажлыг хэрэгжүүлж эхлэх	Бүс нутгийн хөгжлийг хангах, эрдэс түүхий эдийн нөөц, баялгийг өсгөх зорилгоор нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан голлох ашигт малтмалын судалгаа (АМС-2017)-ны ажлын 2018 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар батлан хээрийн судалгааны ажлыг эхлүүлээд байна. Төслийн 2017 оны хээрийн судалгаа болон 2018 оны суурин боловсруулалтын ажлын үр дүнд Увс, Ховд, Баянхонгор, Өмнөговь аймгийн нутагт орших хэтийн төлөвтэй 11 талбайг ялган шаардлагатай талбайд өрөмдлөгийн ажил гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна.	
8		Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг төлөвлөх	2016-2020	АМГТГ БХЗГ		Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн эрэл, хайгуулын ажлыг эхлүүлэх	Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг шинэ талбайд эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тухайлбал Цөмийн энергийн комиссын 2017 оны 04 сарын 15-ны 05 тоот тогтоолын дагуу цацраг идэвхт ашигт малтмалын талбайг ашигт малтмалын кадастрын системд ялган баталгаажуулж хөрөнгө оруулагч болон энэ салбарт үйл ажиллагаа явуулах сонирхол бүхий этгээдүүдэд нээлттэй болгон ялгаж харуулах ажил хийгдсэн.	40
9		Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордод стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, хамтарсан компани байгуулах	2016-2020	УУХҮЯ, АМГТГ, ЦЭКАА БХЗГ		Стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгож, хамтарсан компани байгуулах	"Арева майнс" ХХК, "Гурван сайхан" ХХК-д цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, "Орд ашиглах гэрээ"-г байгуулав. Стратегийн хөрөнгө оруулагчаар Франц Улстай "Арева майнс" ХХК, Чех Улстай "Гурван сайхан" ХХК-ийг тус тус сонгон эзэмшиж байгаа ордод хамтран ажиллаж байна. Эдгээр компаниудын хувьцааны Монголын Засгийн газарт ноогдох хувь эзэмшлийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. "Арева майнс" ХХК-ийн ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг шилжүүлэхээр Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна	70

	10	Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул, геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх	2016-2020	АМГТГ, ЦЭКАА БХЗГ	Хувийн хэвшилийн хөрөнгө оруулалт 20,000.0	Цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийн мэдээг хагас жил тутам Цөмийн Энергийн комиссын ажлын албанд хүргүүлж байна. Тайлбар: Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн чиглэлээр хайгуул хийж буй компаниуд жил бүр хөрөнгө оруулалтын боломжоороо ажлаа гүйцэтгэж буй бөгөөд төрийн байгууллагын үйл ажиллагаанаас хамааралгүйгээр хийгдэж байна. Одоогоор аж ахуйн нэгжтэй мэдээлэл солилцох хэмжээнд ажил явагдаж байна. Судалгаа, хөрөнгө оруулалт татах чиглэлээр Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн болон хайгуулын ажлын мэдээлэл, тогтоогдсон нөөц, өнөөгийн үнэ ханш, зах зээлийн судалгаа, хэтийн төлөвийн талаарх мэдээлэл бэлтгэсэн. Мөн 2017 онд дууссан “Монгол орны газрын ховор элементийн металлогени, түүний төлөвийн судалгаа”-ны төслийн явц болон үр дүнгийн талаар танилцуулга хийгдсэн.	/-/	
2.60. Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.	1	Үндэсний геологийн алба байгуулахдаа хууль, эрх зүй, эдийн засгийн үр өгөөж, гадаад улсуудын ижил төстэй байгууллагуудын талаар иж бүрэн судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулж, ЗГ, УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах, үйл ажиллагааг эхлүүлэх	2017-2020	УУХҮЯ ГБГ	-	Алба байгуулах санал, төслийг боловсруулан холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх	Үндэсний геологийн алба байгуулах ажлын хүрээнд гадаад орнуудын геологийн албадын бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт, хууль эрхзүйн орчны судалж харьцуулсан дүгнэлт хийсэн. Олон улсын жишгийн дагуу "Монгол Улсын Үндэсний Геологийн Алба"-ыг байгуулах хууль, эрх зүйн үндэслэлийн талаар судалгаа хийж, материалиудыг нэгтгэсэн. Судалгааны ажлуудын үр дүнд тулгуурлан албаны бүтэц, схемийг боловсруулж, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын талаар дүгнэлт гаргаж, салбар хоорондын уялдааг хангах зорилгоор БОАЖЯ, ЗТХЯ, БСШУСЯ, БХБЯ-даас албаны үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар санал авсан. Үндэсний геологийн алба байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр судалгааны материалыг нэгтгэн боловсруулж тогтоолын төсөл, танилцуулга бэлтгэн яамдаас санал авах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

	2	Үндэсний геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах, мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг боловсруулах, түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгох	2016-2020	УУХҮЯ ГБГ	Батлагдсан - 323,2 Гүйцэтгэл – 323,2 Санхүүжилт – 323,2	Эрхлэх үйл ажиллагаа ны журмыг батлуулж, мэдээллийг нэгтгэх төсөл хэрэгжиж эхлэх	Үндэсний геомэдээллийн сан хөтөлбөрийн төслийг боловсруулан Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүний хүрээнд “Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам”-ыг боловсруулан УУХҮС-ын 2018 оны А/19 дүгээр тушаалаар батлуулж, Захиргааны хэм хэмжээ тогтоосон актын улсын нэгдсэн бүртгэлийн 2018 оны 3855 дугаарт бүртгүүлсэн. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн “Геомэдээллийн сан-2013” төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2018 оны 4-р сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан.	100
2.61. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.	1	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	2017-2018	УУХҮЯ ГБГ	-	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, батлуулах	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох асуудлаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг боловсруулан “Хууль тогтоомжийн тухай” хуулийн дагуу 2018 оны 6-р сарын 08-ны өдөр салбарын төрийн болон төрийн бус байгууллага, судлаач, эрдэмтэд болон олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийж, ирүүлсэн саналыг нэгтгэсэн. Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	40
	2	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах	2018	УУХҮЯ УУБГ		Хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар батлуулах	Уул уурхайн тухай хуулийн төсөлд Ил тод байдлын асуудлаар бие даасан бүлэг оруулж боловсруулсан.	40
	4	Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2016-2020	УУХҮЯ БХЗГ		Бэлэн болсон 20-иос доошгүй уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулах	Уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулах комисс нийт 7 удаа ажиллаж, 2018 оны эхний хагас жилд нийт 66 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлсэн. Комисс ажлуллахаар хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй холбоо тогтоож бичиг баримтын бүрдэл хангасан 21 уурхайд улсын комисс ажиллаж, цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг өгч, хүлээн авсан. Бусад	100

							бичиг баримтын бүрдэл хангаагүй-21, бичиг баримтын бүрдэлээ ирүүлээгүй 24 аж ахуйн нэгж байна.	
	5	Гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлын төслийг хэрэгжүүлэх, үр дүнгийн тайланг хүлээн авах	2017-2020	УУХҮЯ ГБГ	Батлагдсан - 90.0 Гүйцэтгэл – 0.0 Санхүүжилт – 0.0	Улсын төсөв 250.0 Хамтран хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнг хүлээн авах	МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-ын хамтарсан "Хойт, төв, зүүн Азийн геологийн гүний процесс ба металлогени" төслийн 3 дах шатны үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэж УУХҮС-ын 2018 оны 1-р сарын 31-ний өдрийн А/16 дугаар тушаалаар хүлээн авсан. Хамтын ажиллагааны хүрээнд 2018 оноос хэрэгжүүлэх 4 дэх шатны төслийн геологийн даалгавар, төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар баталсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.	70
	6	Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гадаад орнуудаас ирүүлсэн саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2017-2020	УУХҮЯ ГБГ		Улсын төсөв 1,200.0 Харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Монгол-Орос улсын хил орчмын газар нутгийн геозкологийн болон минерагенийн 1:1000000-ын масштабтай зургийг боловсруулахад хамтран ажиллах болон Оросын Холбооны Улсын холбогдох байгууллагуудад хадгалагдаж буй Монголын Алтай нутгийн геологийн баримтуудад үндэслэн Монголын баруун хойд нутгийн 1:500000-ны масштабтай минералогийн зураг зохиох тухай саналыг бэлтгэн холбогдох газарт хүргүүлсэн.	40
2.62. Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай	1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулах талаар судалгаа хийж, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар тусгай	2017-2018	УУХҮЯ ГБГ		Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээ хялбар, шуурхай болох, олон нийтэд ойлгомжтой болох	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг шинэчилэн боловсруулж, УУХҮС-ын 2018 оны А/28 дугаар тушаалаар батлан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018 оны 3863 дугаарт бүртгүүлсэн. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийг дагалдан 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийг өөрчлөн найруулсан. Ашигт малтмалын тухай хуулийн энэхүү өөрчлөлтийн дагуу Засгийн газрын тогтоол /2014 оны 239, 2015 оны 511, 2017 оны 37, 234/-уудаар батлагдсан сонгон шалгаруулалтаар олгох 13.62 сая гектар талбайгаас хуулиар хязгаарласан, хориглосон 4.07 сая гектар талбайг хасаж тусгай зөвшөөрөл олгох боломжтой 8.68 сая гектар талбайг ялган тогтоосон. Олгох боломжтой талбайд 2018 оны 01 дүгээр сарын 29-	100

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.		зөвшөөрөл олгох, мэдээллийг ил тод, нээлттэй түгээх аргачлалын санал боловсруулах				ний өдрөөс эхлэн хуульд заасан 45 хоногийн хугацаанд орон нутгаас санал авч, нэгтгэсэний үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.	
2.63. Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө.	2	Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах	2018-2019	УУХҮЯ ТБГ	Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсгийг байгуулж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, боловсруулах	Эрдэс баялагийн салбарт үйлчилж буй багц хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ХЗДХС/УУХҮС-ын 2017.12.13-ны өдрийн хамтарсан А/298/А/240 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсгийн ажлын хүрээнд “Газрын тосны тухай” хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахаар ажиллаж, мэдээллээр ханган, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн газрын тосны асуудлаар татварын хөнгөлөлтийн жилийг 5 жилээр нэмэгдүүлэх, орон нутагт орох өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор НӨАТ, гаалийн албан татварын тухай хууль, төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа Сангийн яаманд 2018 оын 5-р сарын 14-ны өдрийн 01/1327 тоотор хүргүүлсэн. Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг томъёоллыг бэлдэж, Ажлын хэсэгт тухай бүр танилцуулж, ЗГ-ын 2018 оны 6-р сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.	100
	3	Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын болон эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	2016-2019	УУХҮЯ ТБГ	Хөрөнгө оруулагч нарт таатай эдийн засаг, эрх зүйн орчин бүрдүүлэх	Зорилтын хүрээнд Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Газрын тосны тухай хууль батлагдахаас өмнө байгуулсан Бүтээгдэхүүнхуваах гэрээнүүдийн үндсэн нөхцөлийг өөрчлөхгүйгээр Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварт нийцүүлэн хэлэлцээр хийж шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг сайдын 2016 оны А/57, 2018 оны А/12 дугаар тушаалаар тус тус байгуулж ажиллав. Ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, тус компанийн эх компаниудын төлөөлөл бүхий ажлын хэсэгтэй уулзалт зохион байгуулсан. Доншен группийн ерөнхий захирал, Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн ерөнхий захиралтай 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдөр уулзаж, санал солилцсон. Мөн дээрх зорилтын хүрээнд “Газрын тосны нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх, хуваарилах, зарцуулах журам”-ыг 2017 оны 1-р сарын 03-ны өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулаад байна. Газрын тосны хайгуулын үйл	70

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

							ажиллагаа явуулж буй компаниудын хувьд Ажлын хэсэг нийт 10 гэрээлэгчтэй уулзалт хэлэлцээр хийсний дүнд хайгуулын үе шатанд хэрэгжиж буй нийт 15 Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдээс 4 гэрээг шинэчлэн байгуулж, 3 гэрээг шинэчлэн байгуулахад бэлэн болгож, 3 гэрээг шинэчлэхээр хэлэлцээ хийж байна. Мөн 2 гэрээний гэрээлэгч гэрээт талбайнуудыг бүхэлд нь буцаах хүсэлтийг гаргаж гэрээг шинэчлэхээс татгалзсан, 2 гэрээний гэрээлэгч гэрээнүүдийг цуцлах тухай хүсэлт гаргасан, 1 гэрээ шүүхийн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.	
4	Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх	2016-2020	УУХҮЯ ТБГ		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 1,000,000.0	Тухайн жилийн зорилтот түвшинд хүрэх	Зүүн бүсийн уул уурхай, газрын тосны ашиглалтын үйл ажиллагаанд шаардлагатай эрчим хүчийг дотоод, гадаад эх үүсвэрээс хангах, нөөц эх үүсвэр бий болгох боломжийг судалж, дүгнэлт гаргах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Эрчим хүчний сайдын хамтарсан А/58/36 дугаар тушаалаар ажлын хэсэг 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан. Үүний дагуу ажлын хэсгийн гишүүд Дорнод, Сүхбаатар аймгуудад байрлах Шинь Шинь ХХК, Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК, Петровичайна Дачин Тамсаг ХХК, Цайрт минерал ХХК болон Эм эл цахиурт овоо ХХК-иудад 2018 оны 4 дүгээр сарын 2-8-ны өдрүүдэд ажиллаж, тус ажлын үр дүнд гарсан дүгнэлтийг ажлын хэсгийн 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралд танилцуулж, ажлын хэсгийн гишүүдээр хэлэлцүүлэн дүгнэлтийг гаргуулав. Үүний дагуу БНХАУ-аас Тамсаг XXI талбай хүртэл 18 км цахилгаан дамжуулах шугам татах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргасан. Мөн газрын тосны асуудлаар татварын хөнгөлөлтийн жилийг 5 жилээр нэмэгдүүлэх, орон нутагт орох өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор НӨАТ, гаалийн албан татварын тухай хууль, төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа Сангийн яаманд 2018 оын 5-р сарын 14-ны өдрийн 01/1327 тоот албан бичгээр хүргүүлсэн. Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд Үндэсний Аудитын газар болон МХЕГ-аас хийсэн шалгалтын дагуу өгсөн үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Мөн Уул уурхайн сайдын Дорнод аймагт ажиллахтай холбогдуулан 2018 оны 5-р сарын 2-7-ны өдрүүдэд Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд томилолтоор ажиллаж, үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавьж ажиллалаа.	40
5	Газрын тосны ордын дэд бүтэц, бүтээн	2016-2020	УУХҮЯ ТБГ		Хувийн хэвшлийн хөрөнгө	Тосон-Уул XIX талбайгаас Баянхошууны хилийн боомт хүртэлх 210,7 км хатуу хучилттай авто замын 3 дугаар хэсгийн 52.5 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр Арж капитал ХХК ажиллаж	70	

	байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх				оруулалт 900,000.0	байгаа ба 2018 оны ажил 4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхэлсэн. 2018 оны 5 дугаар сарын 25-ний өдрийн байдлаар 25.1 км авто замын асфальтбетонон хучилтын ажил дуусч замын хөвөө байгуулах болон тэмдгэлэгээний ажлууд хийгдэж байна. Үлдсэн 27.4 км автозамын далан барих ажил дуусч асфальтбетоноор хучих ажил эхэлсэн байна. Мөн 2 цэгт ус зайлуулах хоолой барих ажил хийгдэж нийт барилгын ажил 67 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Тус компани нь нийт 88 техник хэрэгсэл, 150 ажилчидтай ажиллаж байна.	
					Тухайн жилийн зорилтот түвшинд хүрэх		
6	Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлж, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх	2016-2020	УУХҮЯ ТБГ		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 2,000.0	Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсөвт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, төсвийг тогтмол суулган баталж байгаа ба гэрээлэгчид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмын дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-нд тогтмол хүргүүлэн дүгнэлт гаргуулан ажиллаж байна. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах” журмыг УУХҮС болон БОАЖ-ийн сайд нарын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/50, А/31 тоот хамтарсан тушаалаар батлуулсан ба Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 3870 дугаарт бүртгүүлсэн. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах” журмын хэрэгжилтийг хангуулан, холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах тухай 03/655 тоот албан бичгийг 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдөр АМГТГ-т явуулсан.	40
7	Газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлцлүүдийг хийж, үнэ болон худалдааны таатай	2016-2020	УУХҮЯ ТБГ		Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэтэй уялдуулан газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлэлцээрүүдэ		2018 онд түүхий тос борлуулах гэрээ хэлэлцээрүүд хийгдээгүй ба Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн хувьд 2016 онд байгуулсан гэрээ, Доншен Газрын тос (Монгол) ХХК-ийн хувьд 2017 онд байгуулсан автоматаар сунгагдсан. Үүний шалтгаан нь борлуулах тосны үнийг тооцоолох аргачлал, хэмжих арга, хэмжилтийн цэг нь өөрчлөгдөөгүйтэй холбоотой. Газрын тосны хайгуулын Галба-ХI талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан “Зон Хэн Юу Тиан” ХХК-ийн туршилтын журмаар олборлосон 500 тн газрын тосыг БНХАУ-ын Шандунь мужын “Чин Юань групп” компанид худалдах гэрээний хэлэлцээрийг 2018 оны 5 дугаар сарын 29-өөс 6 дугаар

		нөхцөлийг бүрдүүлэх				д оролцож, үнэ болон худалдааны нөхцөлийг сайжруулах	сарын 3-ны хооронд БНХАУ-ын Шандунь мужын Зибо хотод хийж, түүхий тосыг туршилтын журмаар худалдаалахаар болсон. Доншен газрын тос /Монгол/ ХХК болон UNIPES компани хоорондын түүхий тосны худалдааны гэрээний үнэ, борлуулалт, тээвэрлэлтийн өртөгийн асуудлаарх хэлэлцээрийг 2016 оны 01 дүгээр сард зохион байгуулж, гэрээг сунгасан. Петрочайна Дачин Тамсаг ХХК нь газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлцлүүдийг хийж, үнэ болон худалдааны нөхцөлийг өмнөх жилийн нөхцөл байдалтай уялдуулан сунгасан. Тосны борлуулттай холбогдсон хэлэлцээрт, олборлосон түүхий тосны борлуулалттай холбоотой асуудлаар гэрээлэгч нь гэрээний төслийг АМГТГ-т урьдчилан танилцуулсны үндсэн дээр гэрээг эцэслэн байгуулах, түүхий тос борлуулах асуудлаар хэлэлцээ хийхдээ өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлийг бууруулахгүй, талуудад ашигтай байх нөхцөлөөр хэлэлцээ хийх, тосны борлуулалтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, шинээр байгуулах тохиолдолд АМГТГ-т урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авах, түүхий тосонд шинжилгээ хийлгэж, хүнцэл болон мөнгөн усны агууламжийг тодорхойлох зэрэг нөхцлүүдийг тусгасан.	
8		Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явагдаж буй газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлж, шинээр газрын тосны орд илрүүлэх	2016-2020	УУХҮЯ ТБГ		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 75,000.0	2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 10 гэрээлэгчтэй БХГ-г шинэчлэх талаар уулзалт хэлэлцээр хийж, хайгуулын үе шатыг тохиролцож хайгуулын ажлыг эрчимжүүлэх талаар бодлогын зөвлөмж өгч түр зогсолт буюу моратариум дахин олгохгүй байх талаар АМГТГ-т чиглэл өгч ажиллав. Газрын тосны хайгуулын Борзон-7 болон Ар булаг-29 талбайнуудад хайгуулын өрөмдлөгийн ажил явагдаж байна. Газрын тосны илрэлтэй Галба-ХI талбайн гэрээлэгчтэй хийсэн уулзалтаар газрын тосны илрэл бүхий талбайд үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлэх, нөөцийг нарийвчлан тогтоох талаар зөвлөмж өгөв. Газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд шинээр хайгуулын 2 талбайг олон улсад нээлттэй зарласан хэдий ч захиалгын материал ирүүлээгүй байна. Газрын тосны хайгуулын Хөх нуур-18 талбайд БХГ байгуулсан Эн Пи Ай ХХК, Сулинхээр-23 талбайд БХГ байгуулсан Шунхлай энержи ХХК, Богд-4, Онги-5 талбайд БХГ байгуулсан Капкорп ХХК компаниудын газрын тос хайх аж ахуйн үйл ажиллагааны Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан, Эргэл-12 талбайд шинээр БХГ байгуулсан Смарт Ойл ХХК, Ар булаг-29 талбайд БХГ байгуулсан Макм Ойл ХХК компаниудад газрын тос хайх Тусгай зөвшөөрлийг шинээр олгосон.	70
						Газрын тосны хайгуул, үнэлгээний ажил эрчимжиж, тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэх		

	9	Газрын тос болон уламжлалт бус газрын тосны хуримтлал байж болох газарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх	2016-2020	УУХҮЯ ТБГ	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 5,000.0	Газрын тосны 25 талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаагаас 2016 онд Эргэл XII, Арбулаг XXIX талбайд БХГ-г гэрээг шинээр байгуулсан. Мөн нүүрсний давхаргын метан хийн 5, шатдаг занарын 3, газрын тосны 10, нийт 18 талбайд эрлийн гэрээ байгуулан, хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Жи Өү Эйч ХХК нь Газрын тосны тухай хуулийн 16-р зүйлийн дагуу 2016 оны 1-р сарын 15 -нд “Номгон-IX” газрын тосны хайгуулын талбайд НДМ хийн эрлийн ажил хийж гүйцэтгэх гэрээг Газрын тосны газартай (ГТГ, хуучнаар) байгуулсан. Эрлийн ажлын хүрээнд өмнөх хайгуул судалгааны материалыг нэгтгэх, тойм нөөцийн үнэлгээ, хайгуулын ажлын хөтөлбөр боловсруулах ажлуудыг гүйцэтгэж, Газрын тосны тухай хуулийн 17.1-р заалтын дагуу 2016 оны 7-р сарын 21-ний өдөр ГТГ-аар дүгнэлт гаргуулсан байна. Газрын тосны тухай хуулийн 17.2-р заалтын дагуу “Номгон-IX” талбайд байгуулах нүүрсний давхаргын метан хийн Бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний төслийг Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)-т өргөн барьж, 17.4-р заалтын дагуу АМГТГ-тай БХГ-ний хэлэлцээрийг хийж гүйцэтгэн 2017 оны 5-р сарын 3-ны өдөр хэлэлцэн тохирсон БХГ-ний төслийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)-нд ирүүлсэн. Гэрээний төсөлд 2017 оны 8 дугаар сард, 2018 оны 2 дугаар сард яамдуудаас санал авч ЗГХЭГ-т Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн боловч холбогдох материалыг буцаагаад байна. “Говийн гарц” ХХК нь Газрын тосны газар /хуучин нэрээр/-тай 2014 онд эрлийн гэрээ байгуулж, эрлийн ажлын тайлангаа 2017 оны 2 сард АМГТГ хүлээлгэн өгсөн бөгөөд 2017 оны 11-р сарын 01-ний өдөр АМГТГ-ийн “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын техникийн зөвлөл”-өөр уг тайланг хэлэлцэн хүлээн авсан. “Говийн гарц” ХХК нь газрын тосны тухай хуулийн дагуу эрлийн гэрээний хүрээнд хийгдсэн ажлын үр дүнд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулахаар Бүтээгдэхүүн хуваах гэрээ /БХГ/ байгуулах хүсэлтээ 2018.01.3-ны өдөр Ашигт малтмал, газрын тосны газар /АМГТГ/-т ирүүлсэн байна. Уг гэрээний төслийн 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр УУХҮЯ-нд ирүүлсэн. Гэрээний төслийг судлан үзээд бүх яамдуудаас гэрээний төсөл болон Засгийн газрын тогтоолын төсөлд санал авч нэгтгэж байна.	70
	10	Хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр	2016-2018	УУХҮЯ ТБГ	Гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн	“Дашваанжил ХХК-ийс тавьсан хүсэлтийн дагуу 2018 оны 2 дугаар сард тус компанийн төлөөлөлтэй уулзалт хийж, Тосон-Уулын ордоос олборлож буй шингэнээс ялган авч буй ууссан хийг Япон	70

		газрын тосны олборлолтоос гарч байгаа газрын тосны ууссан хийг ашиглах чиглэлээр судалгаа хийх, ашиглах			хөрөнгө оруулалт 100.0	улсад шинжлүүлэх талаар хэлэлцэн, шаардлагатай мэдээ, материалыг гаргаж өгсөн ба ууссан хийн дээж авах ажлыг зохион байгуулсан. БХГ-т Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тосны орд газраас олборлосон шингэнээс ялган авсан ууссан хийн хэмжээ, зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд: БХГ-т Тосон-Уул XIX талбайгаас нийт 10,666,957 м3 хийг ялгасанаас, 6,432,365 м3 хийг халаах зууханд, 508,428м3 хийг цахилгаан генераторт тус тус ашиглаж, илүүдэл буюу 3,726,164 м3 хийг бамбардсан /шатаасан/ байна. Та-1 олборлолтын нэгдсэн байгууламжийн өдөр тутмын мэдээнээс харахад хүйтний улиралд хоногт дунджаар 1800м3, дулааны улиралд 1100м3 хийг цахилгаан генераторт ашигласан байна. БХГ-т Тамсаг XXI талбайгаас нийт 8,417,740 м3 хийг ялгасанаас, 6,633,832 м3 хийг халаах зууханд, 603,523м3 хийг цахилгаан генераторт тус тус ашиглаж, илүүдэл буюу 1,180,385 м3 хийг бамбардсан байна. Та-2 олборлолтын нэгдсэн байгууламжийн өдөр тутмын мэдээнээс үзэхэд хүйтний улиралд хоногт дунджаар 2500м3, дулааны улиралд хоногт дунджаар 1450м3 хийг цахилгаан генераторт ашигласан байна. Тосон-Уул XIX талбайн хувьд 500кВт-ын 2 хийн генератортой бөгөөд үүний нэгийг тогтмол ажиллуулдаг, Тамсаг XXI талбайн хувьд 600 кВт-ын 4 хийн генератортой бөгөөд үүнээс 1-ээс 2-ыг тогтмол ажиллуулдаг байна. Хийн генераторын хүчин чадал болон тоо хэмжээг нэмэгдүүлснээр үйлдвэрлэх эрчим хүчний хэмжээг нэмэгдүүлэх бөгөөд шатааж буй (бамбардаж буй) хийг бүрэн ашигласан тохиолдолд 1.5-3 МВт орчим эрчим хүчийг гарган авах боломжтой гэсэн судалгааны дүн гарсан.	
11	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй талбайд ой хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зурвас бүсийг байгуулах	2016-2020	УУХҮЯ ТБГ	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 100.0	Хаврын хуурайшилтын үе эхэлсэнтэй холбогдуулан галын аюулаас хамгаалах зурвас бүс байгуулах шаардлагыг гэрээлэгчид тавьж, Тамсаг XXI талбайн галын аюулгүйн зурвасыг үйлдвэрлэлийн бааз болон нэгдсэн байгууламжийг, мөн цооногуудыг тойруулан галын аюулгүйн бүс, Тосон-Уул XIX талбайн үйлдвэрлэлийн бааз, нэгдсэн байгууламж, цооногуудаас 20-50 метр зайтай, 5-8 метр өргөн, 3-5 метр гүнтэй галын аюулгүйн зурвасыг татаж дуусгасан.	70	
				Зурвас байгуулах ажлыг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт нь суулгуулах, хэрэгжүүлж хэвшүүлэх			

	12	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах	2016-2020	УУХҮЯ ТБГ		Улсын төсөв 2.5 "Олборлох үйлдвэр лэлийн ил тод байдлын санаачилга"-д хамруулан тайланг жил бүр авах	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 1-р сарын 12-ны өдрийн А/06 дугаар тушаалаар “Эрдэс баялгийн гэрээний мээдээллийг ил тод болгох” үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, тус Ажлын хэсэг нийт 10 удаа хуралдаж одоогоор 363 гэрээг ил тод болгохоор бэлэн болгоод цахим хуудаснаа байршуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Тус хэлэлцүүлгээс гаргасан Дүрмийн төслийн бүтэц, агуулгыг сайжруулах, олон улсын стандарт, монгол улсын хууль тогтоомж, мөрдөгдөж буй стандартад нийцүүлэхэд чиглэсэн санал, шүүмжийг дүрмийн төсөлд тусган боловсруулж байгаа ба дүрмийн төслийг Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд аж ахуй нэгжүүдийн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамрагдсан талаар судалгаа хийсэн ба гэрээлэгч компаниудыг ил тод байдлын санаачилгад хамрагдах талаар зөвлөмж өгч ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, “Петро Матад” ХХК, “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед” ХХК-иуд уг санаачлагад хамрагдаад байна.	40
2.64. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	2	Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг зохион байгуулах	2016-2020	УУХҮЯ БХЗГ		- Нэгдсэн зохион байгуулалтад оруулах судалгаа хийх	Бичил уурхайн холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангах, хувиараа ашигт малтмал олборлох хууль бус үйл ажиллагааг бичил уурхайн зохион байгуулалтад оруулах, албажуулах, байгаль орчны хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор МХЕГ, ЦЕГ, АМГТГ-тай хамтран ажиллаж байна. Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай №322-А/242 тоот хамтарсан тушаалын дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01/02 тоот хяналт шалгалтын удирдамж батлагдсан бөгөөд Налайх дүүргийн нутаг дэвсгэрт нүүрс олборлолт явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хамтран хийж гүйцэтгэсэн. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай 308 тоот тушаалын дагуу Налайх дүүргийн нутаг дэвсгэрт хууль бусаар нүүрс олборлож байгаа иргэдийн эрүүл мэнд, амь нас хохирох явдлыг таслан зогсоох, санал зөвлөмж гаргах зорилгоор тус дүүргийн иргэдийн дунд зөвлөлдөх санал асуулга зохион байгуулах ажлын хэсэгт холбогдох саналыг хүргүүлэн ажилласан. МХЕГ-т болон хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа ихээр төвлөрсөн	70

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

						Архангай, Төв, Сэлэнгэ аймгуудын хяналт, мониторингийн ажлын үр дүнг нэмэгдүүлэх, МХЕГ-ын мэдээллийн системд мэдээлэл оруулах ажлын чанарыг сайжруулах зорилгоор 4 ширхэг дрон программ хангамж, GPS-ийн хамт ТБУТ-өөс нийлүүлэхээр Удирдах зөвлөлөөс шийдвэрлэсэн.	
2.65. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна.	2	Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангах	2016-2020	УУХҮЯ БХЗГ	Дэд бүтцийн хөгжлийн төсөл хэрэгжүүлэх	Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрийн төслийг боловсруулсан ба салбар хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор Үндэсний хөгжлийн газарт төслийг хүргүүлээд байна.	/-/
2.67. Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ.	2	Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх	2017-2018	УУХҮЯ УУБГ	Журам батлагдан мөрдөгдөж эхлэх	Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын төсөл, нөлөөллийн шинжилгээний тайлан боловсруулж батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/88 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд журмын төслийг боловсруулсан.	40

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2.69. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	2	Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах	2017-2018	УУХҮЯ ГБГ		Хууль тогтоомжийн төслүүдийг боловсруулан, батлуулах	“Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ерөнхий сайдын 2017 оны 17-р захирамжаар хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, уялдуулан зохицуулах, тайлагнах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус Зөвлөл байгуулсан. Зөвлөлийн бүрэлдэхүүнд 4 дэд салбар зөвлөл байгуулж, холбогдох чиглэлээр хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Хүнд үйлдвэрийн бодлогын газартай хамтран “Эрдэнийн чулуу, үнэт металлын боловсруулалт, түүний эргэлтийн тухай хууль”-ийн төсөл дээр ажиллаж байна.	70
	3	Алтны геологийн судалгаа, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын хэмжээг өсгөн нөөцийг тогтвортой нэмэгдүүлэх	2017-2018	УУХҮЯ ГБГ	Батлагдсан - 1740.0 Гүйцэтгэл – 1528,0 Санхүүжилт - 1528,0	Улсын төсөв 1,000.0 Хэтийн төлвийн үнэлгээ хийх, алтны ордын баялаг, нөөцийн хэмжээг тогтоох	Монгол орны төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлвийн үнэлгээ хийх геологийн судалгааны ажлын “ТЗМ-Алт-2017” төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар баталсан. Төслийн 2018 оны төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн 4-р сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлуулсан. Энэхүү төслийн судалгааны ажлаар хэтийн төлөв бүхий 79 талбай, сонирхол татахуйц хэд хэдэн эрдэсжсэн цэг, илрэл, хувирлын бүсүүдийг тогтоосон. 2018 оны хээрийн судалгааны ажлыг 5-р сарын 15-аас эхлүүлсэн бөгөөд эхний ээлжинд Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түмэнцогт, Түвшинширээ болон Хэнтий аймгийн Галшар, Баянхутаг, Баян-Овоо сумдын нутагт орших алтны хүдэржилт, эрдэсжилттэй объектуудыг шалгаж, үнэлгээ өгөх зорилттой ажиллаж байна. Цаашид Дорнод аймгийн хойд, зүүн, зүүн урд, Сүхбаатар аймгийн баруун өмнөд, өмнөд, Хэнтий аймгийн хойд, баруун хойд, төв, урд хэсгүүдийг эрэл-үнэлгээний ажилд хамруулах ба үүний үр дүнд төлөвлөгөөт онд нийт нутаг дэвсгэрийн 30%-ийг судална. 2018 оны 6-р сарын эхний байдлаар ЭБМЗ-ийн 5 удаагийн хурлаар алтны 18 шороон орд, 3 үндсэн ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэж, хүлээн авсанаар улсын нөөцийн санд 18.1 тн алтны нөөцийг нэмж бүртгэсэн.	100
	6	Ашиглалтад оруулахад бэлэн болсон алтны уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад оруулахад	2016-2020	УУХҮЯ БХЗГ		- Алтны олборлолтын хэмжээ нэмэгдэх	2018 онд Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасны дагуу Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших “Тэргүн майнинг” ХХК-ийн, Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Эм Жи Жи И Си” ХХК, “Их ундарга майнинг” ХХК-ийн, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын нутагт орших “Хатантүшиг трейд” ХХК-ийн алтны шороон ордын уурхайнуудыг байнгын ашиглалтад Улсын комисс хүлээн авсан.	40

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

	дэмжлэг үзүүлэх							
	7	Бичил уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судалж хэрэгжүүлэх	2016-2019	УУХҮЯ БХЗГ		-	Сайдын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/47 дугаар тушаалаар байгуулагдсан “Алтны нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгох” үүрэг бүхий ажлын хэсэг 03 дугаар сарын 20-ны өдөр хуралдсан. Ажлын хэсгийн эхний хурлаар ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Мөн алтны сорьц тогтоох, худалдан авах нэг цэгийн үйлчилгээний төвийн байршлыг хуралд оролцогчид Баянхонгор болон Дархан-Уул аймгууд байх нь зүйтэй гэж 100 хувийн саналаар баталсан. Алтны худалдааны гарал үүсэл, ил тод байдлыг хангах талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах ажлыг яаралтай хийх шаардлагатай байгааг хуралд оролцогчид онцолсон. Алтны худалдаа эрхлэгчдийг бүртгэлжүүлэх, гэрчилгээжүүлэх, эсвэл тусгай зөвшөөрөл олгох замаар тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх нь Монголбанкинд тушаагдаж буй алтны гарал үүслийг ил тод болгоход ач холбогдолтой тул энэ асуудлыг судалгааны хүрээнд оруулан дүгнэлт гаргах нь зүйтэй гэж үзсэн. Судалгааг гүйцэтгэх ажлын холбогдох зардлыг ТБУТ-аас санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.	40
2.70. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.	4	Барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах	2017-2020	УУХҮЯ ХҮБГ		Гадаад зээл 800,000.0	ЗГ-ын 2018 оны 2 дугаар тогтоолоор ГТБУ-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг МУ-ын Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх шийдвэр гарсантай холбогдуулан УУХҮЯам, ТӨБЗГ, Хөгжлийн банк болон Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК нар дөрвөлсөн Зээлийн болон Барьцааны гэрээг 2018 оны 04 дүгээр сарын 13-ний өдөр байгуулсан. Үйлдвэрийн гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” хүртэлх салаа төмөр замын ажлын Ерөнхий гэрээг 2018 оны 03 дугаар 30-ны өдөр “УБ Төмөр зам” ХНН болон “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нарын хооронд байгуулсан” Дээрх	40

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

						Үйлдвэрийн барилгын ажил явагдах	салаа төмөр замын техник, эдийн үндэслэл болон нарийвчилсан зураг төслийг УБ төмөр замын Техникийн бодлого, зураг төсөл, инженерийн алба гүйцэтгэж дуусган ажил гүйцэтгэх гэрээ 2018 оны 06 дугаар сарын 06-ний өдөр “МГТБҮ” ТӨХХК-тай байгуулсан.- “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” хүртэлх хатуу хучилттай автозамын ажлын Ерөнхий гэрээг 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Батлан хамгаалах яам МГТБҮ ТӨХХК нар байгуулсан бөгөөд автозамын техник, эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан зураг төслийн ажлыг “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-иар гүйцэтгүүлж байгаа бөгөөд ажил гүйцэтгэх гэрээг Батлан хамгаалах яам болон “МГТБҮ” ТӨХХК нар 2018 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгуулаад байна. “Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр” хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын Ерөнхий гэрээг 2018 оны 03 дугаар сарын 06-ний өдөр “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК болон “МГТБҮ” ТӨХХК нар байгуулсан. ЦДАШ-ын техник, эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан зураг төслийн ажлуудыг гүйцэтгэж байна. Үйлдвэрийн талбайн тэгшилгээ, үйлдвэрийг хашаажуулах болон ойн зурвас хийж гүйцэтгэх ажлын ерөнхий гэрээг БХБЯ болон “МГТБҮ” ТӨХХК нар 2018 оны 05 дугаар сарын 02-ний өдөр байгуулсан.	
2.71. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.	3	Үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулах	2017-2020	УУХҮЯ ХҮБГ		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 862,400.0 Үйлдвэрийн барилгын ажил явагдах	Хугацаа болоогүй.	/-/
2.72. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.	3	Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэр байгуулах	2017-2018	УУХҮЯ ХҮБГ		Үйлдвэр ашиглалтад орох	Төмөртэйн уурхайд байгуулах хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн барилгын ажлыг 2018 оны 8 дугаар сард эхлүүлж 2020 оны 9 дүгээр сард дуусган мөн оны 12 сард үйлдвэрийг бүрэн ашиглалтанд хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлууд хийгдэж байна.	/-/

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

	4	Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах	2018-2020	УУХҮЯ ХҮБГ		Үйлдвэрийн барилгын ажил эхлэх	Хугацаа болоогүй	/-/
	6	Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, импортын хэмжээг бууруулах	2017-2020	БХБЯ ХҮБГ		Төр, хувийн хэвшлийн түншлэл 100,000.0 Төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалт сайжирч, барилгын салбар дахь гангийн импортын хэмжээ буурах	Төмрийн хүдэр, баяжмал экспортлох төмөр замын тээврийн тарифыг уян хатан болгох асуудлаар “Улаанбаатар төмөр зам” ХНН, болон Төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбооны төлөөллийг оролцуулан УУХҮ-ийн Сайдтай уулзалт зохион байгуулав. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Металлургчдын холбоотой хамтран дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай хаягдал төмөр боловсруулдаг гангийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаа, техник-технологийн түвшин, бүтээгдэхүүний чанар, стандартын шаардлага хэрхэн хангаж байгаа байдалтай газар дээр танилцах маршрут гарган, анхан шатны судалгааны ажлыг хийж, үйлдвэрүүдтэй газар дээр танилцахаар ажиллаж байна.	/-/
2.73. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.	5	Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, барилгын зураг төсөл боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах	2018-2020	УУХҮЯ ХҮБГ		Барилгын ажил эхлэх	Хугацаа болоогүй	/-/
						-		40

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2.74. Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.	1	Улаанбаатар хотод жилд 15,000 тн тос, тосолгооны материал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжих	2016-2019	УУХҮЯ ХҮБГ	Үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэх	Төсөл хэрэгжүүлэгч "Интер стандарт нефть" ХХК нь ХБНГУ-ын "EDL Anlagenbau" компаниар үйлдвэрийн ТЭЗҮ-г гүйцэтгүүлж дуусан 2016 оны 04 дүгээр сард Аж үйлдвэрийн яамны /хуучнаар/ ШУТЗ-өөр үйлдвэрийн ТЭЗҮ-г хэлэлцүүлэн дэмжүүлсэн. Төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 43 сая ам.доллар бөгөөд үнээс "Интер стандарт нефть" ХХК нь өөрийн хөрөнгөөр төслийн нийт хөрөнгө оруулалтын 20%-г, 60%-г Германы "НуроVereinsbank"-ны зээлийн эх үүсвэрээр үлдсэн 20%-ийн МУ-ын Хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн эх үүсвэрээр тус тус санхүүжүүлэхээр тохиролцож шаардлагатай бичиг баримтыг хүргүүлээд байна.	
2.75. Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ.	1	Автомашин, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэр, технологийн парк байгуулахыг дэмжих	2017-2020	УУХҮЯ ХҮБГ	Үйлдвэр, технологийн парк байгуулах судалгааны ажлууд хийгдэх	"Автомашин, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэрлэл, технологийн парк байгуулах боломж нөхцөл" сэдэвт зөвлөх үйлчилгээний Үнэлгээний хороо 2018.04.24-ний өдөр хуралдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд гүйцэтгэгчээр шалгарсан ШУТИС-ийн Механик, тээврийн сургуультай 2018 оны 5 дугаар сарын 17-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд судалгааны эхний хувилбарыг бэлэн болгоод байна.	40
2.92. Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.	2	Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх	2016-2018	БХБЯ БХЗГ	Судалгааны үр дүнг хэлэлцүүлэх	ШУТИС-ын дэргэдэх Усны судалгааны төвөөс Хөрсний усыг үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах, энэ чиглэлээр судалгаа хийхэд шаардагдах төсөв, хөрсний усыг ашиглах төслийн саналыг үндсэн хэрэгжүүлэгч БХБЯ-нд ирүүлсэн ба асуудлыг судалж байна.	/-/
2.99. Шивээ-Овоо, Тэвшийн говь болон	3	Хашаат цав, Тэвшийн говийн орд	2018-2020	ЭХЯ БХЗГ	Төслийн суурь судалгааны	Гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй.	/-/

бусад нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлнэ.		газруудыг түшиглэн том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам, нүүрсний уурхай байгуулах төслүүдийг эхлүүлэх				ажилд дэмжлэг үзүүлэх		
ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН								
3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ.	10	Уул уурхай, шинжлэх ухааны чиглэлд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэх	2018	ЦЭКАА БХЗГ		Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төвийн байрны асуудлыг шийдвэрлүүлэх , ТЭЗҮ-ийг батлуулах		-/-
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН								
4.1.3. Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга	1	Байгаль орчны үнэлгээ, аудитаар дамжуулан ашиглагч нь	2016-2020	БОАЖЯ БХЗГ		200-250 төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг	Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас хамтран ажиллах санал ирүүлээгүй байна.	-/-

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.		байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх				хянан баталж, хэрэгжилтийг хангуулах		
4.2.3. Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ.	2	Ус ашиглалтыг бүрэн тоолууржуулж, хаягдал бохир усыг цэвэрлэж, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	2017-2020	БОАЖЯ БХЗГ		Усны тоолууртай ус ашиглагчийн тоо болон ус эргүүлэн ашиглалт, дахин ашиглалтыг дэмжиж нэмэгдүүлэх	Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас хамтран ажиллах санал ирүүлээгүй байна.	/-/
4.2.6. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, олборлолтод	1	Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хохирлыг тооцох, нөхөн сэргээх эрх зүйн зохицуулалтыг бий болгох,	2016-2020	БОАЖЯ БХЗГ		Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хохирлыг тооцох, нөхөн сэргээх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/85 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийт 21 аймагт бүсчилэн 10 чиглэлд орон нутагт томилолтоор ажиллаж, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзалт хийж, чиглэл хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/90 тоот тушаалаар Орон нутгийн хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийлгэхтэй холбоотой үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Мөн БОАЖС-д хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллах санал хүргүүлсэн.	40

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

<p>өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ.</p>		<p>нөхөн сэргээлт хийх</p>					
	<p>3</p>	<p>Аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, чадавхийг бэхжүүлэх замаар нөхөн сэргээлтийн ажлын чанар үр дүнг дээшлүүлэх, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх</p>	<p>2017-2020</p>	<p>БОАЖЯ, МХЕГ БХЗГ</p>	<p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААН, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага, нутгийн иргэдийн оролцоотойгоор 300-аас доошгүй га талбайд нөхөн сэргээлт хийх</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/85 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийт 21 аймагт бүсчилэн 10 чиглэлд орон нутагт томилолтоор ажиллаж, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзалт хийж, чиглэл хүргүүлсэн.</p>	<p>40</p>
	<p>4</p>	<p>Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр хэрэгжүүлж, холбогдох стандартуудыг шинэчлэх, сургалт, судалгааны төв байгуулах</p>	<p>2016-2020</p>	<p>БОАЖЯ БХЗГ</p>	<p>Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөрийг батлуулж, холбогдох стандартыг шинэчлэх, аргачлал боловсруулж эхлэх</p>	<p>Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ болон БНСУ-ын Уул уурхайн Нөхөн Сэргээлтийн Корпораци (MIRECO) хамтран БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Монгол улсад Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн чадавхийг бэхжүүлэх” төслийн Мастер төлөвлөгөө боловсруулах багт яамны төлөөлөл оролцож холбогдох санал өгч ажилласан.</p>	<p>40</p>
	<p>5</p>	<p>Орхон, Туул гол болон бусад голуудын хамгаалалтын</p>	<p>2016-2019</p>	<p>БОАЖЯ БХЗГ</p>	<p>Хамгаалалтын бүсэд явуулж байгаа үйл ажиллагаанд тогтмол хяналт</p>	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөлөл орж ажилласан бөгөөд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. Ажлын хэсэг нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн</p>	<p>40</p>

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

	бүсэд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийг хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах, хариуцлагатай уул уурхайн зарчмыг мөрдүүлж усны бохирдлыг бууруулах				тавьж, хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах	нэгжүүдийг технологийн горимын дагуу үйл ажиллагаа явуулах талаар чиглэл, зөвлөмж өгч ажилласан бөгөөд энэ тухай саналыг ажлын хэсэгт хүргүүлсэн.	
6	Баруун бүсэд дүйцүүлэн хамгааллын жишиг төсөл хэрэгжүүлэх	2016-2019	БОАЖЯ БХЗГ		Баян-Айраг, Хотгор, Хөшөөтийн орд газрын биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх	Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас Даян дэлхийн байгаль хамгаалах сан /GEF/ НҮБХХ-ийн буцалтгүй тусламжтайгаар нийт 1,289,863 ам.долларын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Монгол орны баруун бүсэд хөгжлийн сөрөг нөлөөлөл, газрын доройтлыг бууруулах үе шат, дүйцүүлэн хамгааллыг ландшафтын түвшний төлөвлөлт, менежментэд нэвтрүүлэх замаар уул уурхайгаас бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой "Монгол орны баруун бүс нутгийн газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх" төслийн Удирдах хороонд яамны төлөөлөл ажиллаж байна. Удирдах хорооны 2 дугаар хуралдаанд оролцсон. Төслийн хагас жилийн тайлантай танилцаж, санал хүргүүлсэн.	40
Хэрэгжилт /хувь/							61,7

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР